



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/11

Бат-Өлзий сум

Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг  
хангаж ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоол. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт батлах тухай” А/122 дугаар тушаал, аймгийн Засаг даргын “Хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/25 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, жил бүрийн 11 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд сумын нутаг дэвсгэрт хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглох, цуцлах, хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комисс (Н.Бат-Эрдэнэ), багийн Засаг дарга (Ж.Нямтогтох, Д.Дэмиддагва, Д.Бямбасүрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Г.Бямбагарав), Орхон уяачдын холбооны тэргүүн (Н.Орхонтуул) нарт үүрэг болгосугай.

2. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга (цагдаагийн хошууч Д.Энх-Амгалан), Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Г.Цэрэндулам) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН